

Өөрийгөө улам ахиулан хөгжүүлцгээе

Риспо Косей Кай, Ерөнхийлөгч

Нивано Ничикоо

**“Хүн тарьж ургуулах” гэдэг нь алсыг харсан ирээдүйтэй нийгэм,
улс гүрнийг цогцлооход орхиж болохгүй чухал асуудал**



Шинэ оны мэнд хүргэе!

Өнгөрсөн жил манай нийгэмлэгийн 80 жилийн ой тохиосон чухал жил байсан. Энэ жилээс нийгэмлэгийнхээ 100 жилийн ойг зорин, гишүүд та бүгдтэй хамт нэгэн сэтгэлээр сургаал түгээх үйлсэд зүтгэе гэж бодно. Энэ утгаараа миний бие “2019 оны зорилт”-ыг дараах байдлаар тодорхойлж байна.

Тэнгэр газар, байгаль дэлхий хором мөч бүрт бүтээн байгуулалт, өөрчлөлт шинэчлэлтийг хийж байдаг. Бид ч гэсэн энэхүү байгаль дэлхийн зохицлын дагуу нэг газраа зогсолгүй, аливаа зүйлд үргэлж шинэлэг сэтгэлээр хандах чухал.

Энэ жил РКК үүсгэн байгуулагдсаны 81 жилийг угтаж байна. Үүсгэн байгуулагч, Мёокоо багштан болоод ахмад лидерүүд, гишүүд нойр хоолоо хасан хичээж зүтгэсний ачаар манай нийгэмлэгийн 80 жилийн түүх сүндэрлэн боссон билээ. Тэдний ачийг хариулахын төлөө бид нийгэмлэгийнхээ 100 жилийн ойг зорин хүн бүр үргэлж бүтээн байгуулах зам мөрөөр алхана гэсэн зорилго тавин урагшилахыг уриалж байна.

Утгын хувьд өнгөрсөн жилээс ялгарах зүйлгүй байгаа ч энэ зорилгыг РКК нийгэмлэгийн гишүүд та бүхэн үргэлж санаж явах хэрэгтэй.

New Year's Message 2019

Энэ жилийн зорилт дотор гарч байгаа “бүтээн байгуулах зам мөрөөр алхана” гэдэг үг нь зөвхөн “шинэ зүйлийг бүтээх” гэсэн утгыг илэрхийлээгүй.

Бурханы сургаал нь ялах-ялагдах, амжилт-алдаа, шинэ-хуучин зэрэг ойлголтыг давсан асар том үнэлэмжийг чухал гэж үздэг. Ямарч цаг үед өөдрөг гэгээлэг сэтгэл, эелдэг зөөлөн сэтгэл, дулаан сэтгэл нь хүний үйл хэрэгт эрч хүч өгдөг. Хүн бүр гэр бүлдээ, сургууль, ажил дээрээ, амьдардаг бүс нутагтаа, дэлхий дахинд хандан харамгүйгээр өөдрөг, эелдэг, халуун дулаан харилцааг түгээх нь чухал. Түүнчлэн одоо байгаагаасаа нэг алхам ахих нь жинхэнэ утгаараа “бүтээн байгуулах зам мөрөөр алхах” гэсэн үг. Энэхүү жилийн зорилтын гол санааг мартажгүйгээр өөрийнхөө онцлогийг гаргаж, хэрэгжүүлж болох зүйлээсээ эхлэе.

Миний бие РКК нийгэмлэгийн 100 жилийн ой буюу үүсгэн байгуулагдсаны 1 зууны ойг угтан бидний хийх чухал үүрэг бол “хүний нөөц бэлдэх буюу хүн тарьж ургуулах гэсэн үндсэн асуудалд бүх хүчээ зориулах хэрэгтэй” гэж өмнө нь дурьдсан.

“Хүн тарьж ургуулах” гэдэг үг нь Хятадын эртний ном сударт бичигдсэн байдаг.

Саяхан танилцуулсан сургаал түгээлтийн үндсэн чиг шугмын “хавсралт хэсэг” дээр “Хятадын эртний судар бичигт “нэг жилийн төлөвлөгөө бол үр тариа тарь, 10 жилийн төлөвлөгөө бол мод тарь, нэг насны төлөвлөгөө бол хүн тарих (бэлдэх)-с чухал зүйл үгүй” гэсэн нэг мөр байдаг. Үүнийг “гурван тарихын зүйрлэл” гэж нэрлэдэг.

Хүнийг өсгөх, бэлдэх үйл нь “нэг насны төлөвлөгөө”- энэ бол хүн насан туршдаа санаж, хичээх хэрэгтэй сэдэв ба алсыг харсан ирээдүйтэй нийгэм, улс гүрнийг цогцлооход нэн чухал асуудал юм.


Түүнчлэн хүнийг өсгөж бэлдэх үйлийг газрын хөрсөнд модыг нэг нэгээр тарихтай зүйрлэж болно. Хэрэв тарьсан модны үндэс газрын хөрсөнд сайн бэхжиж чадвал тарьсан хүн нь байхгүй болсон ч мод ургасаар л байх болно. Түүн шиг биеэ даасан, эрч хүч дүүрэн хүнийг бэлдэх ямар чухал вэ гэдгийг “хүн тарих (өсгөх, бэлдэх)” гэсэн үгээр давхар илэрхийлж байгаа юм.

Гэр бүл бол хүний төлөвшилд гол нөлөө үзүүлэх орчин.

Эцэг эх хүүхдэдээ шууд нөлөө үзүүлдэг

Хүнийг өсгөж хүмүүжүүлэхэд нэн чухал зүйл бол балчир наснаас нь харьцах харилцаа бөгөөд өөрөөр хэлбэл гэр бүлийн хүмүүжил юм.


Хүний тархи 3-н нас хүртлээ насанд хүрсэн хүний тархины 80 хувь хүртэл хөгждөг ба 5-6 нас хүртэл зан төлвийн хэв шинж нь шийдэгддэг гэнэ. Ой тогтоолт, анхаарал болгоомж зэрэг чадварууд нь 12-13 насанд хамгийн идэвхтэй хөгждөг ба 16-17 нас гэхэд хүн бүрэн төлөвшдөг байна.



Гэр бүл бол хүнийг хүмүүжүүлж төлөвшүүлэх гол орчин. Манай байгууллагын гишүүдийн хувьд өглөө, оройны номын уншлага болон бурхан тахилдаа залбиран мэндчилэх, цай идээ өргөх зэргээр талархалаа илэрхийлэх дүр байдал нь хүүхдийн хүмүүжилд маш чухал нөлөө үзүүлдэг. Хүүхэд эцэг эхийнхээ өөдрөг, эелдэг, дулаан сэтгэлийг мэдэрч өссөн бол аяндаа хүн чанартай хүн болж төлөвших нь гарцаагүй.

Эсрэгээр өдөр бүр эцэг эхийнхээ сэтгэл шингээгүй үг, үйлдлийг харж, сонсож өссөн хүүхэд өөрийн мэдэлгүй түүнийг нь дуурайж, өвлөн авдаг гэж ярьцгаадаг. Мөн хүүхдийг хүчээр далайлган өөрийн санаснаараа байлгасан ч гэсэн тухайн үед үгэнд нь орж байгаа юм шиг харагдлаа ч цаанаа эсэргүүцэх сэтгэл нь нэмэгдэж, сэтгэл нь холдохоос хэтрэхгүй. Хүүхдээсээ хүсч байгаа зүйлээ эхлээд эцэг эхчүүд өөрсдөө хийж үзүүлэх нь чухал юм.

Дорно дахины гүн ухааны мастер хэмээн



алдаршсан Ясүока Масахиро багштаны номонд ийм үг гардаг. “Эцэг хүн хүүхдийнхээ хүндэтгэлийн бай нь байвал зохистой. Эх хүн хүүхдийнхээ энэрэл хайрын суудал байвал зохистой. Яагаад гэвэл гэр орон бол хүүхдийг бойжуулах талбай учраас юм”.

Будааны суулгацыг бойжуулах талбайг урьдчилан боловсруулж бэлдэхгүйгээр намар ургац хураах талаар бодоод ч хэрэггүй гэдгийг тунгааж үзэх бизээ.

Хүмүүс бид бодисадвагийн зам мөрөөр алхах нь Бурхан багшийн туйлын хүсэл

Миний бие “Бурхан багш болон Үүсгэн байгуулагч, Мёокоо багштан шиг энэрэн нигүүлсэх сэтгэл буюу хүнлэг сэтгэл (гэгээлэг, эелдэг, зөөлөн дулаан)-ээр бодисадвагийн зам мөрөөр алхацгаая” гэсэн уриаг та бүгдэд дахин дахин түгээсээр ирсэн.

Бодисадвагийн зам мөрөөр алхах нь Бурхан багшийн биднээс хамгийн ихээр хүсэж буй зүйл бөгөөд Цагаан Лянхуа сударт ч энэ талаар тодорхой дурьдсан байдаг.

Бодисадва гэдэг нь бурханы сургаалд бат итгэж, ойлгож, гэгээрлийн түвшин лүү чин сэтгэлээр зорьж байгаа хүмүүсийг хэлдэг билээ. Өөрөөр хэлбэл бодисадва нь өөрийн сэтгэлээ бурхантай ижилхэн болгохын төлөө хичээдэг хүмүүс гэж хэлж болно. Мөн бодисадва нарын амьдралын эрч хүч нь энэрэл нигүүлсэл гэж сургадаг.

Хүн бүр бодисадва болохын төлөө зорихдоо анхаарах ёстой зүйл бол өөрийн үнэлэмжээр бус бурхан багшийн үнэлэмж гэж хэлж болох “сургаалаас суралцах” үйлийг орхигдуулж болохгүй.

“Суралцах” гэдэг үгний ханз үсэг нь “далавч” ба “бие” гэсэн хоёр ханзнаас бүрддэг. “Далавч” гэдэг нь шувууны далавч ба “бие” гэдэг нь шувууны эх биеийг хэлж байгаа юм. Ангаахай нь өсөж торниод, үүрээ орхих үе дөхөж ирэхэд эцэг эхийнхээ үйлдлийг дуурайж, далавчаа дахин дахин дэвэж, нисэх бэлтгэл хийдэг дүр байдлыг илэрхийлж байгаа юм.

Үүрээ орхин нисэх ангаахай шиг өдөр бүр бурханы сургаалыг зөвөөр ойлгож, түүнийгээ өөрийн үйл хөдлөл, амьдралдаа тусган бодох,

энэ үйлдлийг байнга давтан хийвэл-аажим аажмаар бурханы сэтгэлд ойртон очих болно.


Өдөр бүрийн ийм хичээл зүтгэлийг эх шувуу шиг хажуугаас нь харж, хамгаалах ёстой хүмүүс бол яах аргагүй номын андууд санга нар юм. Ижил сүсэг бишрэлтэй андуудаар хүрээлүүлснээр урам зориг авч, суралцаж, мөн сэтгэл амар үйлийг хийх боломжтой ийм орчин байгаа нь үнэхээр баярламаар.

Магадгүй элсээд удаагүй гишүүдийн дотор “би тийм сүрхий хүн биш болохоор бодисадва болно гэдэг бүтэшгүй зүйл” гэж боддог жаахан өөртөө итгэлгүй хүн байж болно.

Бүх хүнд шунал, уур хилэн, мунхаг хэмээх сэтгэлийн гэм байдаг. Хүмүүс эдгээр сэтгэлийн гэмийг сөргөөр хүлээн авч, хүнд байж болохгүй зүйл хэмээн ойлгох нь элбэг байдаг. Гэвч үнэн хэрэгтээ сэтгэлийн гэмээс үүдэлтэй зовлон шаналал байгаа болохоор л асуудлаа шийдэхсэн гэсэн бодь сэтгэл (гэгээрлийг хүсэх хүсэл) урган гарч ирдэг.

Өөрөөр хэлбэл сэтгэлийн гэм болон гэгээрэл нь нэг зүйл болохыг анзаарах, мөн бусдад түүнийг анзааруулах нь чухал асуудал юм.

Мөн хүмүүст бурхантай ижил нигүүлсэнгүй сэтгэл ч гэсэн байгаа гэж сургадаг. Зовж шаналж байгаа хүний яриаг сонсож өгөөд, нөгөө хүний тань сэтгэл онгойж аврагдахад, тэр хүнээсээ илүү баярлах тохиолдол байдаг. Хүний нүднээс далдуур хог түүх, хандив цуглуулж буй хүнд хандив өргөх, бусдад суудал тавьж өгөх үед бидний сэтгэл юутай ч зүйрлүүлэшгүй сайхан болдог.



New Year's Message 2019

Хүн бүрт агуулагдаж байгаа боломжинд итгэж, бодисадвагийн зам мөрөөр өөрөөсөө эхлэн явах. Улмаар аль болох олон бодисадваг бэлдэх алхамыг эхлүүлэх хэрэгтэй.

Энэ оны 5-р сард хааны суудал залгамжлах ёслол болох ба ингэснээр “Хэйсэй” хэмээх он тооллын хөшиг хаагдана. “Хэйсэй” гэдэг нэрний утга нь “дотроосоо амгалан тайван бол гаднаасаа айх зүйлгүй” гэсэн Хятадын эртний үгнээс гаралтай. Хүн ч тэр, улс орон ч тэр дотроосоо амгалан, тайван байвал тэрхүү байдал гадаад төрхөнд нь илэрч гараад нөлөө үзүүлдэг гэсэн утгатай.

“Хэйсэй”-н он тооллын үед амьдарсан бид бүхэн тэрхүү нэрний цаана агуулагдах утга санааг сайтар тунгааж, амьдралдаа хэрэгжүүлэх нь чухал юм.

Хүнд тулгардаг янз бүрийн асуудлууд нь хэн нэгэн шийдэж, аварч өгөх юм шиг бодоод, хүлээж байхад шийдэгдэхгүй. Бурхан багш,

газар доороос урган гарч ирсэн бодисадва нарт (15-р бүлэг) Цагаан Лянхуа судрыг дэлгэрүүлэхийг даалгасан шиг зовлонгоор дүүрэн ертөнцөд асуудал бэрхшээлтэй нүүр тулж, хамаг чадлаараа амьдарч байгаа хүмүүсийн үйлдэл л асуудлыг шийдэнэ гэж сургадаг.

Тиймээс өөрийгөө огтхон ч гололгүй, бурхан багшийн сургаалд итгэж, ойлгон, нигүүлсэнгүй сэтгэлээр бодисадвагийн зам мөрөөр алхах- энэ л бидний үйл хэргийн зорилго бөгөөд Цагаан Лянхуа судрын хөндсөн гол сэдэв юм.

Үүнийг сайтар сэтгэлдээ тунгааж, энэ жил ч гэсэн та бүхэнтэй хамтдаа гар гараасаа бариад сургаалаа түгээхийг хүсэж байна.

(Косей сонин 2019 оны 1 сарын 6 өдрийн дугаараас)

